

“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХОЙШЛОГДСОН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ






Улаанбаатар хот

2018 оны 4-р сарын 26

Хуралэхэлсэн цаг: 10:20

Хурлаар хэлэлцсэн асуудлууд

1. 2018 оны компанийн үйл ажиллагааны тайлан
2. 2018 оны санхүүгийн тайлан
3. 2019 оны зорилт, төлөвлөгөө
4. Ногдол ашгийн тухай



Хурлын явц:

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Цогтгэрэл: Хурлын дэгийг танилцуулав. Хурлын дэгтэй холбоотой санал хэлэх гишүүд байна уу? Хурлын дэгтэй холбоотой санал өгөх гишүүд **Байхгүй** тул хурлын дэгийг батлав.

- Б.Цогтгэрэл: Тооллогын комиссыг хурлын нарийн бичиг Н.Энхчулуун нарыг сонгоод явчих уу? Та бүхэн ямар саналтай байна?

Санал нэг байгаа тул Тооллогын комиссоор ТУЗ – ийн Нарийн бичиг Н.Энхчулууныг томилох саналыг 100 хувиар зөвшөөрлөө.

Тооллогын комисс ирцийг бүртгэхэд хуралд саналын эрх бүхий 12 135 338,0 ширхэг хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид буюу 76.5% ирцтэй байгаа нь компанийн тухай хуулийн 69.1, компанийн дүрмийн 7.4 –ийг хангаж байна. Мөн Компанийн тухай хуулийн 69.3-т заасны дагуу хүчин төгөлдөр бус гэж үзэж хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд оруулан тооцсон болно. /Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав./

Нийт хувьцааны тоо:	15 869 233
Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо
Б.Осолгүйгэрэл	30 000
С.Баярцэцэг	6 000
Б.Цогтгэрэл	3 548 345
Ц.Чингүүнболд	1 824 000
Ц.Оргилболд	912 000
Б.Нарангуяа	50 000
П.Бүрнээбаатар	3 900
“Би Ди Сек ҮЦК” ХК	5 236 605

2019 оны 4 – р сарын 05 – ны өдрийн хурлаар ирсэн саналын эрх	
Б.Баярсайхан	354 477
Б.Ариунжаргал	20 000
Ч.Цовоо	80 500
Ч.Золбоо	63 580
Н.Бурмаа	10
Н.Дуламжав	1
Ж.Энхтунгалаг	10
Г.Гансүх	5 910
	524 488
Нийт	12 135 383
Нийт хувьцаанд эзлэх хувь	76,5%

Хурлын дэгийн дагуу Хурлыг Б.Цогтгэрэл миний бие даргалаад явчихъя.

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Хурлын хэлэлцэх асуудал 1:

Хурлын дэгийн дагуу Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа 2018 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулна.

Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа:

УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Компанийн захиргаа, санхүүгийн албанд 5, инженер 9, мэргэжилтэй ажилчин-7, машин механизмын-5 үндсэн 26, харуул хамгаалалт, үйлчилгээний-4, нийт 29 ажилтан, ажилчидтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн хэмжээнд дагаж мөрдөх нэн шаардлагатай эрх зүйн баримт бичгүүд болох:

- "Монинжбар хувьцаат компанийн хөдөлмөрийн дотоод журам"
- "Монинжбар хувьцаат компанийн аюулгүй ажиллагааны журам"
- "Монинжбар хувьцаат компанийн хувийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны олголт ба ашиглалтын журам"
- "Монинжбар хувьцаат компанийн инженер техникийн ажилтнуудын ажиллах журам"

зэрэг журмуудыг шинээр боловсруулан баталж, нийт ажилчдад танилцуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Компанийн хэмжээнд хөдөлмөрийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд: инженер-5, жолооч-3 мөн ня-бо, компанийн хуульчтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлав.

Үйл ажиллагааны болон ашиглалтын урсгал зардлыг бууруулах ажлын хүрээнд:

- ОСНААГ-ын харьяа Иргэдэд үйлчлэх 6-р төвтэй байгуулсан гэрээг компанид ашигтайгаар шинэчилж сар тутам 400.000 гаран мянган төгрөгийг халаалтын зардлаас буурууллаа.
- Мобикомын дараа төлбөрт дугааруудын лизингийг ажилтнуудын өөрсдийнх нь нэр рүү шилжүүлж байна.
- Сул орон тоон дээрх НДШ төлөлтийг зогсоов.

Хүлээгдэж байсан өр төлбөрүүдээс: конторын барилгын газрын болон үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын төлбөр, автобаазын газрын төлбөр, хөрөнгийн биржийн өмнөх жилүүдийн хураамж, ажилчдын 2018 оны НДШ, ХАОАТ-ын болон зарим зээл, ажил үйлчилгээний төлбөрийг төлж барагдууллаа.

СУРГАЛТ,НИЙГМИЙН АЖЛЫН ТАЛААР

1.БХБЯамны харьяа Барилгын хөгжлийн төвөөс зохион байгуулсан ХАБЭА-н сургалтад 1 хүнийг сургалаа.

2. Нийт ажилтан, ажилчдын аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2018 оны 8, 9 дүгээр саруудад НМХГ-ын улсын байцаагч н. Эрхэмбаяр болон

ХАБЭА-н зөвлөх инженер н.Чинзориг нараар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг ажлын талбай дээр 2 удаа зохион байгуулав.

3. ИТА-нууд туслах ажилчид, харуулуудыг өвлийн ажлын дулаан гутал, хувцсаар хангав.

4. Хөдөлмөрийн дотоод журам-ын 4.2.10-т заасны дагуу нийт ажилтан, ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд хамруулав.

5. Эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчныг бүрдүүлэх зорилгоор “Ажлын байран дээрх хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл амьдралын зөв дадал зуршил” сэдвээр нийт ажилтнуудад эрүүл мэндийн сургалтыг зохион байгууллаа.

Та бүхэнд хурлаар хэлэлцэх асуудлуудын мэдээлэл цахм болон хэвлэмэл байдлаар хүргэгдсэн байгаа. Та бүхнийг танилцсан байгаа байх. /Тайланг хавсралтаар орууллаа./ Бид энэ онд нэмж гэрээлсэн ажил байхгүй. Өнгөрсөн онд бид НЗДТГ-ын захиалгаар УБГХХХОДХөтөлбөр төслийн хүрээнд “Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх 8070 метр урттай ф600мм-ийн цэвэр ус дамжуулах гол шугамын барилга угсралтын ажил”-аа он дамжин гүйцэтгэж байна.

Хурлаар хэлэлцэх асуудал: 2

2016 оноос хойшхи НӨАТ-ын татварын үлдэгдэл 2016, 2017 оны 2 жилийн сул зогсолтын хугацааны олгогдоогүй цалингийн хуримтлал, иргэд аж ахуйн нэгжээс авсан зээлийн өглөгүүд үүссэн байна.

2018 онд бид Харилцагч Хаан банкнаас төрөөс зарласан сонгон шалгаруулалттай холбоотой санхүүжилт, баталгааны эх үүсвэрийг шийдвэрлүүлэх зорилгоор 300 000 000,0 /гурван зуун сая/ төгрөгийн зээлийн шугам болон нийт 1,4 тэрбум төгрөгийн баталгааны гэрээг байгуулснаас 689 сая төгрөгийг гүйцэтгэлийн баталгаанд, үлдэгдэл 710 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааны эрхийг зээл болгон авсан.

Мөн ББСБ-аас 200 сая төгрөгийн зээл авч шугам хоолойн угсралтын ажлыг гүйцэтгэсэн. 209 оны ажлыг эхлүүлэхэд БНХАЦ-У-аас импортоор оруулж ирж буй шугам хоолойн захиалга, үйлдвэрлэл хийгдээд эхний ээлжээсээ ажлын талбай дээр буугаад байна.

Б.Лхагвадорж: Тасганы ажлын гүйцэтгэл нь 14 хувьтай байна уу? Энэ хувь нийт дүнгээсээ тооцсон байдлаар уу? Н Эй Би ХХК – ийн гүйцэтгэсэн хувь нь хэд бэ?

Б.Нарантуяа: Энэ нийт дүнгээсээ тооцсон байгаа. Түншлэгч тал болох Н Эй Би ХХК 2018 оны байдлаар ажил хийгдээгүй байна. Хийгдээгүй байгаа шалтгаан нь Н Эй Би ХХК – ийн гүйцэтгэх трассын дагуу авто зам хуулах, сэтлэх г.м саадууд гарч ирсэн. Өнгөрсөн онд оройтож ажил эхэлсэнтэй холбоотой Нийслэлийн авто замын газраас зам хуулах, сэтлэх зөвшөөрөл өгөөгүй.

Б.Цогтгэрэл: Урьдчилгаа 10 хувиас Н Эй Би ХХК өөртөө тохирох хувийг? 48 хувийг

Б.Нарантуяа: Анх энэхүү ажлын гүйцэтгэлийн баталгааг Н Эй Би ХХК гаргасан.Тийм учраас гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу орж ирсэн 10 хувь буюу 686 сая төгрөгнөөс 48 хувийг нь авсан байгаа. Гэхдээ ажлаа эхлээгүй бид бас шахаж л байна.

Б.Лхагвадорж: Одоо санхүүжилт 686 сая төгрөгийг авчихаад байгаам уу?

Б.Нарантуяа: 10 хувийн урьчилгаа олгогдсон ч энэ маань эргээд 10 хувийн гүйцэтгэлийн баталгаа болоод явчихдаг. Яг манай бодит гүйцэтгэл бол 4%. Энэ гүйцэтгэлийг Нийслэлийн засаг дарга томилогдоогүй гэсэн шалтгааны улмаас бид 2019 оны 1 сарын сүүлээр авсан байгаа.

Б.Лхагвадорж: Яг авчихаад байгаа гүйцэтгэл нь 14% юм уу. Яг хийсэн ажил нь хэдэн хувьтай байгаа бэ?

Б.Нарантуяа: Яг авсан байгаа нь 14 хувь. Хийсэн ажил маань 4 хувь. Бид 4 хувийн гүйцэтгэл авангуут 10 хувийн урьдчилгааны 15 хувийг дээр нь барьцаа 5 хувийг нь суутгаад авчихаж байгаан. Урьдчилаад авсан учраас гүйцэтгэлээрээ эргэн төлөлт хийгээд явна гэсэн үг.

Манай Тасганы ажлын тендер нь 2017 онд зарлагдсан. Зураг нь 2016 онд хийгдсэн. Төсөвт өртөгийг бид 2017 онд тендерт орохдоо тооцоолсон. Гэтэл бид 2019 онд гүйцэтгэж байгаа болохоор ханшийн зөрүү гарна. Гэхдээ гүйцэтгэлийн дүнд тооцохгүй гэсэн хатуу гэрээтэй.Б.Лхагвадорж: Яг 2019 оны байдлаар нь хийхээр өртөг зардал, ашигийн түвшин нь ямар гарахаар байна вэ?

Б.Нарантуяа: Маш сайн зөв зохион байгуулж байж алдагдалгүй талдаа ажиллана гэж үзэж байна. 2017 оны ханшаар тооцоолсон төсвийг 2019 онд төлбөрийг гүйцэтгэж байна. Аль аль валютын ханш өсчихсөн энэ дээр алдагдал хүлээж байна. Бид хэрвээ өмнө нь байгуулсан үйлдвэрээрээ явсан бол бүр хасах зардал руу орох байсан. 2018 оны 11 сард манай төлөөлөгчид энэ чиглэлийн үйлдвэрлэл эрхэлдэг 10 гаруй үйлдвэрээр явж, газар дээр нь ажилласнаар үйлдвэрээ сольж чадсан нь шугам хоолойг харьцангуй бага үнээр авсан. Төслийн нэгжид учраа ойлгуулж үйлдвэрээ сольж чадсан байгаа. Үйлдвэрээ төслийн нэгжээр хүлээн зөвшөөрүүлж солиулах гэж нэлээн ажиллаж зөвшөөрүүлсэн байгаа. Одоо бид энэхүү ажлыг маш богино хугацаанд зөв зохион байгуулалттай ажиллаж байж ямар ч байсан ард нь гарах ёстой.

Б.Лхагвадорж: Гүйцэтгэлээс санхүүжилт олгох нь хаанаас шийдэгдэх бэ?

Б.Нарантуяа: Эхлээд төслийн нэгжид хянагдаад НХОГ-т хянагдаж зөвшөөрөл олгоод Сангийн яам гүйлгээ хийх эрхийг олгосноор УБГХХХОДХ төсөл гүйлгээ хийдэг байгаа. Энэ үйл явц нэлээн удаашралтайгаас гадна 10 гаруй хүнээр хянагдаж гарын үсэг тамгаар баталгааждаг.

Одоо л гэхэд бид ажил эхлэх зөвшөөрлөө 2019 оны 3 сард л өгсөн. Дарга томилогдоогүй гээд одоо болтол ажил эхлэх зөвшөөрөл маань гараагүй байх жишээтэй.

Б.Лхагвадорж: Заавал жил болгон авдаг уу.

Б.Нарантуяа: Заавал жил болгон авах ёстой. 2019 оны ажил эхлэхэд бид бэлтгэл ажлаа хангаад байна. Техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээгээ хийж дуусаад байгаа.

1 дэх өдрөөс буюу 4 сарын 29 - нөөс СХД – ийн 12 –р хороо буюу Москва хорооллын зүүн талд ажлын талбайгаа гаргана.

Б.Цогтгэрэл: Хэдэн бригад гаргах гэж байна. Миний бодлоор бол 3 бригад гаргах хэрэгтэй. Хугацааны хувьд ч сайн.

Б.Нарантуяа: 2 бригад гаргана. 3 бригад гарвал бүр л сайн байна.

Б.Лхагвадорж: Энэ хурлын материалд 2019 оны орлого дээр нийт ажлын 80% Тасганы ажлын орлого гэж байна. Энэ талыг тодруулбал?

Б.Цогтгэрэл: Шугам хоолой нийлүүлж байгаа учраас энийг оруулсан байгаа. Гол нь банк бусын хүү тусгагдаад л явах ёстой. Санхүүгийнхэн зардлуудаа маш сайн шингээж өгөх ёстойг анхаараарай.

Б.Нарантуяа: БНХАУ-аас оруулж ирж буй шугам хоолойг манайх дааж байгаа. Гүйцэтгэл бичээд ирэхээр Н Эй Би ХХК – ийн дүнгээс шийгэм хоолойн үнэ хасагдаад л явна. Дээрх асуудлуудыг шингээж өгөх байгаа.

Б.Лхагвадорж: Зардлуудаа маш сайн шингээж яг цэвэр гүйцэтгэлийг нь гаргах ёстой байна.

Б.Цогтгэрэл: Гүйцэтгэх захирлын 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сонслоо. Өнгөрсөн жилийн үйл ажиллагааг “Хангалтгүй” гэж үзэж байгаа. Яагаад гэвэл өнгөрсөн жилийн гүйцэтгэсэн ажлыг графикаар шахах боломжтой байсан ч санхүүгийн моделио, төлөвлөлтөө хийж чадаагүйгээс хугацаа алдсан. Энэ бол шинэ гүйцэтгэх захирал, шинэ удирдлагуудад хамраалгүй. Би ТУЗ – ийн даргаар 2018 оны 8 сараас ажиллаж эхэлсэн. Энэ үед бол ажил ид дундаа ороод явж байсан ч явж байгаа үйл ажиллагааг зогсоох учиргүй. Шинээр зохион байгуулалт хийгээд явах бололцоогүй байлаа. Оны эцэст компанийн бичиг баримтын ажлуудыг хийж цэгцэлж авсан нь сайшаалтай байлаа. Үйлдвэрлэлийн хувьд бол хэд хэдэн шалтгаантай: Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчид том жижиггүй анхаарч ажиллан, үйл ажиллагааг нь эрс өөрчлөхгүй бол маш хүнд байгаа компани.
2. Энэ төрлийн компаниудын төсөв зохиогдох, санхүүжилт тавигдах, тендер зарлагдах, гүйцэтгэл хийгдээд ажлаа улсын комисс хүлээлгэн өгөхөд хамгийн багадаа 4 жил, цаашлаад 10 жил сунжирдаг. Энэ хооронд бодит байдал өөрчлөгдсөн байдгаас маш олон эрсдэлүүд гарч ирдэг. Үүнийг төр ойлгохгүй. Энэ нь үйл ажиллагаанд нь нэмэлт зардлууд гарч ирдэг. Жишээлбэл: 4 жилийн дотор валютын ханш 34% хувь унасан байна. Ажлын бараа материалын 60-70% нь импортоор орж ирдэг. Энэ нь асар их алдагдал хүлээдэг.
3. Компанийн зохион байгуулалтад маш их дутагдлууд байсан. Энэ байдлыг сайн ярилцаж, ТУЗ дээр ярилцаж байж өөрчлөлт оруулсан. Компанид шинэ хүмүүсийн зохион байгуулалтыг хийж байна.

4. Компани зөвхөн тендер төвтэй үйл ажиллагаагаар бус чөлөөт зах зээл дээр гарч ажиллах, компанийн гадаад харилцааг өргөжүүлэн ажиллахад шинээр томилогдсон гүйцэтгэх удирдлагад санал болгоод байна.

Б.Цогтгэрэл: Та бүхнээс 2019 оны төлөвлөгөөтэй холбоотой асуух зүйл байна уу? 2019 оны санхүүгийн төслийг батлах уу.

Бүх гишүүд 100% зөвшөөрч ХЭХ-аас 2019 оны санхүүгийн төслийг зөвшөөрсөн тогтоолыг баталлалаа.

Б.Лхагвадорж: Хурлаараа батлаад ТУЗ – ийн ээлжит хурлаараа ярилцаад явах хэрэгтэй байх. Мөн ТУЗ – ийн даргын 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн байдлын дүгнэлтийн дагуу Гүйцэтгэх удирдлагад үүрэг өгөх саналтай байна.

Хурлаар хэлэлцэх асуудал: 3

- 2019 гэрээт ажлыг хугацаандаа гүйцэтгэх,
- Санхүүгийн сахилга батыг сайжруулах

2019 оны төсвийн төлөвлөгөө

ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны гүйцэтгэл	2019 оны /мян.төг/
		Төлөвлөгөө
Нийт орлого	858836,2	5603942,4
Нийт зардал	857130,7	5254837,9
Цэвэр ашиг	1534,9	314194,1
Борлуулалтын орлого	841386,6	5589542,4
ББӨ	174896,6	4799364,6

Хурлаар хэлэлцэх асуудал 4

2018 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлантай холбоотой Ногдол ашиг тараах бололцоо байхгүй байгаа тул 2019 оны 01 – р сарын 16 – ны өдрийн ТУЗ19/02 тоот тогтоолоор Ногдол ашиг таарахгүй байх шийвэр гарсан байна./ТУЗ – ийн тогтоолыг танилцуулав/

Шийдвэрлэсэн нь:

- Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайланг “Хангалтгүй” гэж дүгнэн, 2019 оны үйл ажиллагааг эрчимжүүлэхэд гүйцэтгэх удирдлагад үүрэг даалгавар өгөх,
- Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайланг “Хангалтгүй” гэж үзэж ТУЗ – өөс Гүйцэтгэх удирдлагад санхүүгийн сахилга батыг сайжруулахад анхаарал тавин ажиллах үүрэг даалгавар өгөх
- Компанийн 2019 оны зорилт, төсвийн төлөвлөгөөг “Хангалттай” гэж үзэх
- Компани 2019 онд Ногдол ашиг таарахгүй байхаар тус тус шийдвэрлэлээ.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

Б.ЦОГТГЭРЭЛ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТ ХӨТӨЛСӨН

ТУЗ – ИЙН НАРИЙН БИЧИГ

Н.ЭНХЧУЛУУН